

## Стратеги төлөвлөгөө батлах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2015 оны 122 дугаар тогтоолоор батлагдсан Багануур Үйлдвэрлэл, Технологийн Парк ОНӨТҮГ-ын дүрмийн 5.1.8, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Өмчийн харилцааны газрын даргатай 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан Контрактын 3.26 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын тогтвортой хөгжил, найдвартай ажиллагааг хангах, байгальд ээлтэй шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зорилгоор хөгжлийн үзэл баримтлалыг тусгасан Паркийн хөгжлийн дунд хугацааны стратери төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Паркийн хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Үйлдвэрлэл, технологийн алба /Д.Алтангэрэл/-нд даалгасугай.

3. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж байхыг Нягтлан бодогч /Л.Оюунцэцэг/-д даалгасугай.

ДАРГА

Ч.ЭЛБЭГСАЙХАН